

ТЕНДЕРИЙН УРИЛГА

1. Увс аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн байгууллага, орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн 2017 оны санхүүгийн тайланд Монгол улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.8-д заасан хугацаанд аудит хийх БАГЦ-1: УВС-ЗҮ/2017-01, БАГЦ-2: УВС-ЗҮ/2017-02, БАГЦ-3: УВС-ЗҮ/2017-03 дугаар бүхий ажлыг гүйцэтгүүлэхээр төлөвлөж байгаа тул Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх саналаа ирүүлэхийг урьж байна.
2. Зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийг хураангуй жагсаалтад орсон дараах зөвлөхүүдэд хүргүүлж байна. *[Зөвлөхийн хураангуй жагсаалтыг хавсаргав. хавсралт №02]*
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн энэхүү зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон чанарын үнэлгээний аргад үндэслэн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгоно.
4. Зөвлөхийн саналын урилга нь дараах бүрдэл хэсгүүдтэй байна. Үүнд:

Бүлэг 1 – Урилга

Бүлэг 2 – Зөвлөхийн санал бэлтгэх зааварчилгаа
(Тендерийн өгөгдлийн хүснэгтийн хамт)

Бүлэг 3 – Техникийн санал – жишиг маягт

Бүлэг 4 – Санхүүгийн санал – жишиг маягт

Бүлэг 5 – Ажлын даалгавар

Бүлэг 6 – Гэрээний жишиг маягт

5. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
6. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017-12-20 өдрийн 09.00-17.00 цагийн хооронд авч болно.
7. Тендерийг 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 10.00 цагаас өмнө Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 10.30 цагаас Увс аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 304 тоот өрөөнд нээнэ.
8. Тендерийн бичиг баримтын үнэ багц тус бүр 30000 /гучин мянга/ төгрөгийг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан дахь 100150024401 тоот дансанд байршуулна.
9. Тендерийн багцын мэдээллийг хавсаргав. /хавсралт №02/

Захиалагчийн хаяг:

Увс аймаг дахь Төрийн аудитын газар
Утас: 70453317, 70453721